Тайлант онд төсвийн хөрөнгөөр 78,268.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 15,722.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллагуудаас шилжүүлэн авч, 5,251.334.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй авчээ. Холбогдох байгууллагуудын шийдвэрээр тайлант онд 287,737.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Сумын Соёлын төвийн 240 хүний суудалтай барилга, сургуулийн барилга, дотуур байрыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулж, үнэ төлбөргүйгээр орлогод авснаас үндсэн хөрөнгө 5,177.588.7 мянган төгрөгөөр өсөхөд нөлөөлжээ.

*Хүснэгт 7. Байгууллагын үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | ИТХ | ЗДТГ | Сургууль | Цэцэрлэг | Соёл | ЭМТ | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| Эхний үлдэгдэл | 17,648.5 | 1,323,715.0 | 1,927,156.5 | 649,820.0 | 255,512.1 | 757,165.2 | 4,931,017.3 |
| Нэмэгдсэн | 3,550.0 | 211,312.8 | 3,380,923.0 | 95,443.6 | 1,723,721.0 | 50,375.3 | 5,465,325.7 |
| Худалдан авсан | 3,550.0 | 15,659.9 | 20,337.1 | 12,810.0 | 7,520.0 | 18,391.9 | 78,268.9 |
| Шилжүүлэн авсан | - | 135,722.7 | - | - | - | - | 135,722.7 |
| Бусад | - | 59,930.2 | 3,360,585.9 | 82,633.6 | 1,716,201.0 | 31,983.4 | 5,251,334.1 |
| Хасагдсан | 9,440.6 | 45,943.6 | 191,910.6 | 7,429.7 | - | 33,012.5 | 287,737.0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Акталсан | 9,440.6 | 44,626.6 | 9,172.8 | 7,429.7 | - | 3,012.5 | 73,682.1 |
| Шилжүүлсэн | - | 1,317.0 | 182,737.9 | - | - | 30,000.0 | 214,054.9 |
| Эцсийн үлдэгдэл | 11,758.0 | 1,489,084.2 | 5,116,168.8 | 737,834.0 | 1,979,233.1 | 774,528.0 | 10,108,606.0 |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрт урт хугацаат зээл байхгүй, богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 2,767.1 мянга, эцсийн үлдэгдэл 3,755.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 266.3 мянган төгрөгөөр өссөн байна. Сумын ерөнхий боловсролын сургууль өмнөх оны 2,762.3 мянган төгрөгийн өглөгийг барагдуулж ажиллаж, оны эцэст өглөггүй ажилласан бол бусад төсөвт байгууллагууд оны эцэст өглөгтэй гарсан ба нийт өглөгийн 58.4 хувийг ОНХС-ийн, 26.9 хувийг ЭМТ-ийн, 12.3 хувийг Соёлын төвийн, 2.4 хувийг Цэцэрлэгийн өглөг эзэлж байна.

*Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| № | Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Үүнээс: Ажиллагсадтай холбоотой | Байгууллагад төлөх өглөг | Бараа үйлчилгээний зардлын өглөг |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | ОНХС | | 2,194.7 | 0.0 | 2,194.71 | 0.0 |
| 2 | ЕБС | 2,762.3 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 3 | Цэцэрлэг | 0.0 | 85.4 | 0.0 | 85.38 | 0.0 |
| 4 | ЭМТ | 0.0 | 1,011.7 | 52.5 | 0.0 | 959.2 |
| 5 | Соёлын төв | 4.8 | 463.8 | 213.80 | 250.00 | 0.0 |
| | ДҮН | 2,767.1 | 3,755.6 | 266.3 | 2,530.1 | 959.2 |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,514,490.6 мянга, эцсийн үлдэгдэл 9,678,784.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,164,294.2 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал | 1,516,243.74 | 1,516,243.74 | - | 15.7 |
| Хуримтлагдсан үр дүн | 1,845,254.00 | 7,079,244.47 | 5,233,990.47 | 73.1 |
| Өмнөх үеийн үр дүн | 173,915.70 | 1,914,950.32 | 1,741,034.63 | |
| Тайлант үеийн үр дүн | 1,671,338.30 | 5,164,294.15 | 3,492,955.85 | |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,152,992.87 | 1,083,296.55 | (69,696.32) | 11.2 |
| **Дүн** | **4,514,490.61** | **9,678,784.76** | **5,164,294.15** | **100** |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 9,678,784.8 мянган төгрөг болж өмнөх оноос 5,164,294.2 мянган төгрөгөөр өссөн нь сумын сургуулийн байр, 240 хүний суудалтай Соёлын төвийн барилгыг үнэ төлбөргүй авснаас шалтгаалжээ.

### 3.5.10 Орлогын данс

Жинст сумын ИТХ-ын 2020.12.18-ны өдрийн хуралдааны 2/12 дугаар тогтоолоор Жинст сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 4,250.0 мянга, аймгийн төсөвт 88,800.0 мянга, нийт 93,050.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр төлөвлөгөөг 118.2 хувиар биелүүлснээс улсын төсөвт төвлөрөх татварын

орлогыг 317.0 мянга, аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 16,900.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт 10. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **А. Улсын төсөв** | **4,250.0** | **4,567.0** | **317.0** | **107.5** |
| 1. ААНБ-ын орлогын татвар | 1,500.0 | 2,921.4 | **1,421.4** | 194.8 |
| 2. Нэмэгдсэн өртгийн албан татвар | 1,800.0 | 250.0 | **(1,550.0)** | 13.9 |
| 3. Агаарын бохирдол /авто/ | 950.0 | 1,395.6 | **445.6** | 146.9 |
| **В.Аймгийн төсөв /712/** | **88,800.0** | **105,383.1** | **16,583.1** | **118.7** |
| 1. ЦТХА орлого /Суутган -1/ | 76,500.0 | 93,205.2 | **16,705.2** | 121.8 |
| 2. АТӨЯХ-ийн татвар | 1,000.0 | 1,084.2 | **84.2** | 108.4 |
| 3. ҮХЭХ-ийн татвар | 9,500.0 | 10,154.1 | **654.1** | 106.9 |
| 4. Газрын төлбөр | 1,800.0 | 939.6 | **(860.4)** | 52.2 |
| **Нийт дүн** | **93,050.0** | **109,950.1** | **16,900.1** | **118.2** |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ*

Татварын орлогын биелэлтийг нэр төрлөөр нь авч үзвэл нэмэгдсэн өртгийн албан татвар, газрын төлбөрөөс бусад орлогыг 8.4-94.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Жинст сумын ИТХ-ын 2020.12.18-ны өдрийн хуралдааны 2/12 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 34,200.0 мянга, хүү торгуулийн орлогыг 5500.0 мянга, нийт 39,700.0 мянган төгрөгөөр баталсан байна.

*Хүснэгт 11. Сумын төсөвт төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| 1.Татварын орлого | 34,200 | 51,431 | 17,231 | 150 |
| 1.1.ИОТХ | 5,000.00 | 24,783.30 | 19,783.30 | 495.67 |
| 1.2. Хадгаламжийн хүүгийн орлого | 16,000.00 | 18,993.10 | 2,993.10 | 118.71 |
| 1.3. ҮХЭХ борлуулсны татвар | 3,000.00 | 60.00 | -2,940.00 | 0.00 |
| 1.3. Бууны татвар | 1,000.00 | 1,049.60 | 49.60 | 104.96 |
| 1.4.Улсын тэмдэгтийн хураамж | 1,500.00 | 827.30 | -672.70 | 55.15 |
| 1.5.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр | 6,000.00 | 5098.4 | -901.60 | 84.97 |
| Түгээмэл тархацтай АМНАТ | 500.00 | | -500.00 | 0.00 |
| 1.7.Газрын төлбөр | 1200 | 619 | -581.00 | 51.58 |
| 2.Татварын бус орлого | 5,500 | 4,488 | -1,013 | 81.59 |
| 2.1.Хүү торгуулийн орлого | 5500 | 4487.5 | -1,012.50 | 81.59 |
| Нийт дүн | 39,700.00 | 55,918.20 | 16,218.20 | 140.85 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ*

Тайлант онд ИТОХ-ын төлөвлөгөөг 19,783.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь малчдын ноос, ноолуурын орлогоос суутгасан татварыг Сангийн яамнаас сумын дансанд төвлөрүүлсэн нь голлох нөлөөллийг үзүүлжээ.

Сумын татварын орлогыг зөв төлөвлөөгүйгээс ҮХЭХ борлуулсны татвар, түгээмэл тархацтай АМНАТ, улсын тэмдэгтийн хураамж зэрэг орлого тасарсан байна.

Жинст сумын татварын орлогын гүйцэтгэлийн мэдээг 449,9 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байгаад зөвлөмж хүргүүлэв.

Сумын ИТХ-ын 2020.12.18-ны өдрийн хуралдааны 2/12 дугаар тогтоолоор сумын ЗДТГ-ын өөрийн орлогыг 1,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн гүйцэтгэлээр Хаан банкны халаалтын төлбөрийн 700.0 мянган төгрөгийн орлогыг оруулжээ.

Дээрх тогтоолоор сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн орлогоор тайлант онд 89,600.0 мянган төгрөгийг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 78,127.9 мянган төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 87.2 хувиар биелүүлсэн байна.

### 3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 2,257,853.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,168,589.7 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 2,069,513.4 мянган төгрөгийг урсгал зардалд, 99,076.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн системийн дээд байгууллага нь нэг хүнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.12.18-ны өдрийн хуралдааны 2/12 дугаар тогтоолоор нийт 2,145,534.7 мянган төгрөгийг баталсан байна.

*Хүснэгт 12. Байгууллагуудын төсвийн төсөл, батлагдсан төсөв /мянган төгрөгөөр/*

| Орлогын төрөл | Төсвийн төсөл | Анх батлагдсан төсөв | Зөрүү |
|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 90,088.20 | 74,463.70 | (15,624.50) |
| Засаг даргын Тамгын газар | 404,050.00 | 383,689.60 | (20,360.40) |
| Сургууль | 650,432.70 | 590,863.30 | (59,569.40) |
| Цэцэрлэг | 240,592.70 | 260,286.80 | 19,694.10 |
| Эрүүл мэндийн төв | 471,134.70 | 471,134.70 | - |
| Соёлын төв | 198,907.00 | 138,643.50 | (60,263.50) |
| Сум хөгжүүлэх сан | | 148,400.00 | 148,400.00 |
| Орон нутгийн хөгжлийн сан | | 78,053.10 | 78,053.10 |
| **Нийт дүн** | 2,055,205.30 | 2,145,534.70 | 90,329.40 |

*Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудас, сумын ИТХХ-ын тогтоол*

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.18-ны өдрийн хуралдааны 2/12 дугаар тогтоолоор анх баталсан 2,145.534.7 мянган төгрөгийг сумын ИТХ-ын хуралдааны 2021.06.30-ны өдрийн 3/08 дугаар тогтоолоор төсвийг 60422.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,205,957.0 мянган төгрөгийн төсөв баталсан ба ЕБС, Цэцэрлэг, Соёлын төвийн төсвийг аймгийн Засаг даргын 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар 51,896.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр сумын нийт төсөв 2,257,853.4 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1,154,156.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 22,134.6 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 78,053.1 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 832,624.8 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 95,945.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 73,939.7 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын ... ОНХНС-ийн

урамшууллыг бүрэн авч, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 1,166.3 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авч, туслах үйл ажиллагааны орлогыг 300,0 мянга, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг 11,472.1 мянган төгрөгөөр дутуу биелүүлж, оны эцэст зардлын хэмнэлтээс 4,375.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, 31,882.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 13.Байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | ОН-ын төсөвт төвлөрүүлсэн | Улсын төсөвт төвлөрүүлсэн |
|---|---|---|---|---|---|---|
| Засаг даргын Тамгын газар | 411,368.30 | 409,010.67 | 2,357.6 | 99.4 | 2,057.63 | 0.0 |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 74,463.70 | 73,639.88 | 823.8 | 98.9 | 823.82 | 0.0 |
| Ерөнхий боловсролын сургууль | 655,680.30 | 638,074.32 | 17,606.0 | 97.3 | 0.0 | 17,150.84 |
| Цэцэрлэг | 240,846.30 | 234,055.73 | 6,790.6 | 97.2 | 0.0 | 6537.0 |
| Эрүүл мэндийн төв | 471,134.70 | 461,590.36 | 9,544.3 | 98.0 | 0.0 | 8194.7 |
| Соёлын төв | 156,422.30 | 154,928.70 | 1,493.6 | 99.0 | 1,493.60 | 0.0 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 99,537.80 | 99,076.29 | 461.5 | 99.5 | 0.0 | 0.0 |
| Сум хөгжүүлэх сан | 148,400.00 | 72,136.88 | 76,263.1 | 48.6 | 0.0 | 0.0 |
| Нийт дүн | 2,257,853.4 | 2,142,512.8 | 115,340.6 | 94.9 | 4,375.0 | 31,882.5 |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Жинст сумын байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,142,512.8 мянган төгрөг буюу 94,9 хувьтай байгаа нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, нормативд зардлыг хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 230,241.9 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт өгснөөс бараа үйлчилгээний зардалд 188,355.2 мянган төгрөг зарцуулж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад 13,337.5 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 24,838.8 мянган төгрөгийг олгож, оны эцэст хэмнэлтийн 3,710.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 14. Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлага, төвлөрүүлэлт /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | ЗДТГ | ИТХ | ЕБС | Цэцэрлэг | ЭМТ | НИЙТ |
|---|---|---|---|---|---|---|
| **НИЙТ ОРЛОГО** | **17,927.6** | **1,000.0** | **42,610.3** | **11,211.6** | **157,492.4** | **230,241.9** |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 17,927.6 | 1,000.0 | 42,610.3 | 11,211.6 | 67,629.4 | 140,378.9 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0 | 0 | 0 | 0 | 3,596.0 | 3,596.0 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 0 | 0 | 0 | 0 | 86,267.0 | 86,267.0 |
| **НИЙТ ЗАРЛАГА** | **17,927.6** | **1,000.0** | **42,610.3** | **11,211.6** | **157,492.4** | **230,241.9** |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | 17,927.6 | 1,000.0 | 4,399.0 | 11,211.6 | 153,816.9 | 188,355.2 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0 | 0 | 24,838.8 | 0 | 0 | 24,838.8 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0 | 0 | 13,337.5 | 0 | 0 | 13,337.5 |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 0 | 35.0 | 0 | 3,675.4 | 3,710.4 |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

## 3.7 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 100 мэдээллээс 92 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлснээс орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг бүтэн жилээр болон 2021 оны 3,4 дүгээр сард, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний мэдээллийг 2,3,4 дүгээр сард хоцроож байршуулсан байна.

## 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, 6,345.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг барагдуулж, менежментийн захидлаар 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

## 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

*<u>Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга</u>*

Аудитын төлөвлөсөн горим сорилын дагуу Жинст сумын Засаг даргын харьяаны байгууллагуудын санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайлантай тулгахад дараах алдаа илэрч, аудитын явцад э-тайланд залруулав. Үүнд:

1. Сумын Эрүүл мэндийн төв Эрүүл мэндийн даатгалын сангаас Ковид цар тахлын өвчлөлийн эмчилгээний төлбөрийн санхүүжилт дутуу ирсний улмаас оны эцэст 172,153.0 мянган төгрөгийн авлагатай гарсныг тодруулга тайланд тус авлагыг 5-аас дээш жилийн насжилтаар бүртгэсэн, төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоог э-тайланд оруулаагүй;
2. Сумын сум хөгжүүлэх сангаас 2021 онд 2 аж ахуйн нэгжид 70,000.0 мянган төгрөгийн зээл олгосон байхад авлагын тодруулга тайланд 5-аас жилээс дээш насжилттайгаар, сумын Соёлын төв 2021 онд үүссэн 463.8 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн акттай байхад тооцоо нийлсэн актгүйгээр тайлагнасан;
3. Сумын ерөнхий боловсролын сургууль тайлант онд үнэ төлбөргүй ирсэн 3,350,635.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Э-тайланд үр дүнгийн тайланд оруулахдаа 120018 дансаар тайлагнаагүй 120045 дансаар тайлагнасан байна;
4. Төсвийн гүйцэтгэлийн тайланд албан хаагчдын тоог сумын сургууль 1, ИТХ 1, ЭМТ 1, Соёлын төв 1-ээр зөрүүтэй оруулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 төсөлтэй сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4

байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамрагдсан байна.

*Хүснэгт 15.Аудитын хэлбэр, өгсөн санал дүгнэлт*

| № | Байгууллагын нэр | Аудит хийсэн байгууллагын нэр | Дүгнэлтийн хэлбэр |
|---|---|---|---|
| 1 | Засаг даргын Тамгын газар | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар | Хязгаарлалттай |
| 2 | Ерөнхий боловсролын сургууль | | Зөрчилгүй |
| 3 | Эрүүл мэндийн төв | "Баянташаагийн эх аудит" ХХК | Зөрчилгүй |
| 4 | Цэцэрлэг | | Зөрчилгүй |
| 5 | Иргэдийн төлөөлөгчийн хурал | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар | Түүвэрт хамрагдсан |
| 6 | Соёлын төв | | Түүвэрт хамрагдсан |
| 7 | Орон нутгийн хөгжлийн сан | | Түүвэрт хамрагдсан |
| 8 | Сум хөгжүүлэх сан | | Түүвэрт хамрагдсан |

*Эх сурвалж: Байгууллагуудын аудитлагдсан санхүүгийн тайлан*

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн аудитаар тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан, байгууллагын даргын тушаалаар томилогдсон тооллогын комисс хөрөнгийг бүрэн тоолоогүй, тооллогын дүнд үндэслэн нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй, байгууллагын 2020 оны санхүүгийн тайлангийн аудит, 2021 оны завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс зөрчил давтагдан гарсны улмаас сумын Засаг даргын Тамгын газар “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 636,244.6 мянган төгрөгийн 29 алдаа зөрчил илрүүлснээс 64,748.7 мянган төгрөгийн 20 алдаа зөрчил нь санхүүгийн тайлагналтай холбоотой, 571,495.9 мянган төгрөгийн 9 зөрчил нь Шилэн дансны тухай хууль, “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүйгээс гарсан зөрчил байна.

Аудитаар төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд илэрсэн нийт 636,244.6 мянган төгрөгийн 29 алдаа, зөрчлийн 980.0 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 28,022.3 мянган төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 67,578.4 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага өгч, 539,663.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15 зөвлөмжийг хүргүүлжээ.

*Хүснэгт 16.Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)*

| Байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Залруулга | | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн зөрчил | | | | | | | | | | |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | 340.0 | - | - | - | - | - | - | 1 | 340.0 |
| Засаг даргын Тамгын газар | 12 | 26,394.9 | 2 | 980.0 | 3 | 3,308.5 | 2 | 1,730.0 | 5 | 20,376.4 |
| Ерөнхий боловсролын сургууль | 2 | 3,456.5 | - | - | 2 | 3,456.5 | - | - | - | - |
| Эрүүл мэндийн төв | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Цэцэрлэг | 1 | 2,000.0 | - | - | 1 | 2,000.0 | - | - | - | - |
| Соёлын төв | 1 | 7,000.0 | - | - | 1 | 7,000.0 | - | - | - | - |
| Орон нутгийн хөгжлийн сан | 2 | 13,300.0 | | | | | | | 2 | 13,300.0 |
| Сум хөгжүүлэх сан | 1 | 12,257.3 | | | 1 | 12,257.3 | | | | |
| СТА зөрчлийн дүн | 20 | 64,748.7 | 2 | 980.0 | 8 | 28,022.3 | 2 | 1,730.0 | 8 | 34,016.4 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал** | | | | | | | | | | |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Засаг даргын Тамгын газар | 2 | 34,896.9 | - | - | - | - | 1 | 22,576.9 | 1 | 12,320.0 |
| Ерөнхий боловсролын сургууль | 2 | 317,528.0 | - | - | - | - | - | - | 2 | 317,528.0 |
| Эрүүл мэндийн төв | 1 | 29,226.1 | - | - | - | - | - | - | 1 | 29,226.1 |
| Цэцэрлэг | 1 | 47,217.5 | - | - | - | - | 1 | 43,271.5 | 1 | 3,945.7 |
| Соёлын төв | 1 | 105,805.7 | - | - | - | - | - | - | 1 | 105,805.7 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 1 | 36,822.0 | - | - | - | - | - | - | 1 | 36,822.0 |
| Сум хөгжүүлэх сан | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Нийцлийн аудитын дүн** | **9** | **571,495.9** | **-** | **-** | **-** | **-** | **2** | **65,848.4** | **7** | **505,647.5** |
| **Нийт дүн** | **29** | **636,244.6** | **2** | **980.0** | **8** | **28,022.3** | **4** | **67,578.4** | **15** | **539,663.9** |

*Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэл*

**Харьяа байгууллагуудад илэрсэн алдааны дийлэнх хувийг Шилэн дансны тухай хуулийг бүрэн мөрдөөгүйгээс шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулаагүй, орхигдуулсан, төсвийн хэмнэлтийг "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн 43 дугаар тогтоолыг зөрчсөн зөрчил эзэлж байна.**

*Хүснэгт 17..Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)*

| **Харьяа төсвийн байгууллагуудын дүн** | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **№** | **Алдаа зөрчлийн утга** | **Дүн** | **Тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн утга** | **Буруутай албан тушаалтан** | |
| **Ерөнхий боловсролын сургууль** | | | | | |
| 1 | Жижүүр Л.Баянжаргалд 2021 оны 6 сард амралтын цалин, үр дүнгийн урамшуулал, цалинд 1,165.1 мянган төгрөг олгохоор тооцсон байхад гарт олгох цалин дээр нэмж 706.5 мянган төгрөгийг нэмж 1,871.7 мянган төгрөгийг олгосон байна. Мөн илүү олгосон 706.5 мянган төгрөгөөс 2021 оны 7 сард НДШ-д 81.2 мянга, ХАОАТ-ын 75.3 мянган төгрөгийг мэдээлж төсвөөс төлсөн | 863.0 | Төсвөөс илүү олгосон цалингийн 706.5 мянга НДШ-ийн 81.2 мянга, ХАОАТ-ын 75.3 нийт 863.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов. | Дарга, нягтлан бодогч | М.Бибиш, Б.Чулуундорж |
| 2 | ковид-19 цар тахал гарсантай холбоотой сургууль хичээллээгүйтэй бөгөөд мах болон бусад хүнсний материал муудаж Жинст сумын сургуулийн захирлын 2021.10.01-ний өдрийн 46 дугаар тушаалаар 2,593.5 мянган төгрөгийн хүнсний материалыг акталсан байна. | 2593.5 | Устгасан 2,593.5 мянган төгрөгийн хүнсний материалыг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов. | Дарга, нягтлан бодогч | М.Бибиш, Б.Чулуундорж |
| 3 | 2021 онд нийт 941,775.0 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 27 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5 гүйлгээний 184,395.8 мянга, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) 85,869.2 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна. | 270265.0 | Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ зэрэг 3 мэдээллийг хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | М.Бибиш, Б.Чулуундорж |
| 4 | Үдийн цайны зардал нь оны эхэнд | 47263.0 | Цаашид Засгийн | Дарга, нягтлан | М.Бибиш, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ба 7,133.0 мянга, дотуур хүүхдийн хоолны зардлыг оны эхэнд 58,963.8 мянган төгрөг батлагдаж 40,130.0 мянган төгрөгийг бууруулж аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтэст бүлэг хооронд гүйлгэн зарцуулах хүсэлт өгч аймгийн Засаг даргын "Төсөвт зохицуулалт хийх тухай " А/289, А/742 дугаар захирамжуудаар цалин, НДШ, эд хогшил худалдан авах, гамшгийн эрсдэлийн сан зэрэг зардлуудад тус тус гүйлгэн зарцуулсан байна. | | хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол болон журмыг хэрэгжүүлэн ажиллах | | |
| | **ДҮН** | **320,984.5** | | | |
| **Засаг даргын Тамгын газар** | | | | | |
| 1 | Байгууллагын даргын тушаалаар ажилтанд сахилгын шийтгэл ногдуулахдаа ажилтанд илүү цалин олгож, Хөдөлмөрийн тухай хуулийг зөрчсөн байна | 53.1 | Илүү олгосон цалинг ажилтнаар буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоох | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Т.Эрдэнэцэцэг, Б.Батбаяр |
| 2 | Сумын Засаг даргын 2021.12.15-ний өдрийн А/176 дугаар тушаалаар "Орон нутгийн мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангах, удирдах бүрэлдэхүүний албан хэрэгцээнд зориулсан хувцас хэрэгсэл худалдан авах"-д 3,000.0 мянган төгрөгийг зарцуулах шийдвэр гарсны дагуу 2021.12.17-ний өдөр иргэн М.Отгонжаргалаас нэг бүр нь 120.0 мянган төгрөгийн ажлын хувцсыг худалдан авч, албан хаагчдад олгож, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчсөн байна. | 3000 | Албан хаагчдаар хувцасны үнийг буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Т.Эрдэнэцэцэг, Б.Батбаяр |
| 3 | Байгууллагын даргын хөрөнгө захиран зарцуулах тухай 12,863.1 мянган төгрөгийн 8 тушаал, 6,300.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй, орлогыг 3413.8 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна. | 22576.9 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах албан шаардлага өгөх | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Т.Эрдэнэцэцэг, Б.Батбаяр |
| 4 | Аймгаас өвс тэжээл хүргүүлсний замын зардлыг жолооч О.Хүрэлтогоод олгохдоо хувь хүний орлогын албан татварт 3 дугаар сард 88.8 мянга, 4 дүгээр сард 66.6 мянган төгрөгийг суутгасан атлаа орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, жолооч Б.Алтангэрэлд 1,000.0 мянган төгрөгийн тээврийн хөлснөөс 100.0 мянган төгрөгийн татварыг суутгаагүй Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчсөн байна. | 255.4 | Хувь хүний орлогын албан татварыг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Т.Эрдэнэцэцэг, Б.Батбаяр |
| 5 | Жинст сумын Засаг даргын 2021.12.22-ний өдрийн а/182 дугаар захирамжаар "Хүүхдэдээ тайлагная, хүүхдээ сонсоё" ээлжит чуулганыг сумын ЕБС-тай хамтран зохион байгуулж, 2,600.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,300.0 мянган төгрөгөөр ухаалаг самбар авахаар баталж, 2021.12.23-ний өдөр "Некст электроникс" ХХК-д 1,300.0 мянган төгрөг шилжүүлсэн байхад хөрөнгийг орлогод аваагүй байна. | 1300 | "Некст электроникс" ХХК-аас худалдан авсан ухаалаг самбарыг хөрөнгөд бүртгэх албан шаардлага өгөх | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Т.Эрдэнэцэцэг, Б.Батбаяр |
| 6 | Завсрын аудитаар 2021 онд шинээр худалдан авсан болон өмнөх онд үлдэгдлээр байсан хөрөнгөөс түүврийн аргаар сонгож тулгахад 43 ширхэг 430.0 мянган төгрөгийн гэрэл цомгийг хүмүүст тараасан байхад зарлагадаагүй зөрчил илэрч, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй байна. | 430 | Гэрэл зургийн цомгийг тараасан жагсаалтыг анхан шатны баримтад хавсарган, бүртгэлээс хасах албан шаардлага өгөх | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Т.Эрдэнэцэцэг, Б.Батбаяр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | Байгууллагын албан хаагчдын эзэмшиж байгаа эд хөрөнгийн картыг бүрэн хөтлөөгүй, албан хаагчдын гарын үсгээр албажуулаагүй, хөрөнгийн тооллогоор бараа материалыг тоолоогүй, тооллогоор тоолсон үндсэн хөрөнгийн дүн бүртгэлийн дүнгээс зөрүүтэй, нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй, тайлант онд акталсан хөрөнгийг устгал хийсэн актыг үйлдээгүй байна. | 0 | Албан хаагчдын ашиглаж байгаа эд хөрөнгийн картыг бүрэн хөтөлж, албажуулах, эд хөрөнгийн тооллогыг чанартай хийж, тооцоо бодсон актаар баталгаажуулж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах. | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Т.Эрдэнэцэцэг, Б.Батбаяр |
| 8 | Тайлант онд болон өмнөх онд бэлтгэж, үндсэн хөрөнгөд бүртгэсэн 12520.8 мянган төгрөгийн 7 хөрөнгийн ашиглах жилийг 0-ээр, 2019 онд бүртгэсэн 3855.6 мянган төгрөгийн 3-р багийн контор гэсэн хөрөнгийн ашиглах жилийг -1-ээр оруулснаар тухайн хөрөнгөд элэгдэл бодоогүй байна. | 16376.4 | Хөрөнгийг ашиглалтад оруулсан хугацаанаас нь тооцож, ашиглагдах жилийг санхүүгийн программд оруулж, хөрөнгийн элэгдлийг тайлант онд үнэн зөв илэрхийлэх. | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Т.Эрдэнэцэцэг, Б.Батбаяр |
| 9 | Цалингийн болон томилолтын урьдчилгааг өглөгөөр бүртгэсэн, санхүүгийн программд засврын аудит хийснээс хойш орлогын дүнг засварласан, мөнгөн гүйлгээний журналд гүйлгээний утга, харилцагч байгууллагын нэрийг иргэдийн харилцах нэрээр оруулсан байна. | 0 | Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар"-ын дагуу бүртгэлийг хөтөлж, санхүүгийн программд төлбөрийн хүсэлтийг үндэслэн гүйлгээний утга, харилцагч байгууллагын нэрийг бүрэн оруулж байх. | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Т.Эрдэнэцэцэг, Б.Батбаяр |
| 10 | Бэлнээр олгосон 17,062.1 мянган төгрөгийн гүйлгээний кассын тайлан гаргалгүй төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөөгүй байна. | 0 | Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг мөрдөж ажиллах. | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Т.Эрдэнэцэцэг, Б.Батбаяр |
| 11 | Тайлант онд төсвийн хөрөнгөөр 70.0 мянган төгрөгийн ДВД уншигч, 210.0 мянган төгрөгийн компьютерын хард авч үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна. | 280 | Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгөөс бараа материалд залруулах | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Т.Эрдэнэцэцэг, Б.Батбаяр |
| 12 | Хаан банктай байгуулсан гэрээний дагуу халаалтын 7 сарын хугацаанд нийт 700.0 мянган төгрөг төлснийг өөрийн орлогоор бүртгэлгүй, урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр бүртгэсэн байна. | 700 | Санхүүгийн тайланд санхүүжилтийг бууруулах, орлогыг нэмэгдүүлж залруулах | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Т.Эрдэнэцэцэг, Б.Батбаяр |
| 13 | Сумын Засаг даргын 2021.10.25-ний өдрийн а/126 дугаар захирамжаар сумын цагдаагийн албаны автомашины засварт 4,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. | 4000 | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах. | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Т.Эрдэнэцэцэг, Б.Батбаяр |
| 14 | Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг зөрчин Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, бөхийн барилдаан зохион байгуулахад 12,320.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. | 12320 | Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж, Төрийн наадмаас бусад ойн арга хэмжээнд төсвөөс мөнгө зарцуулдаг явдлыг таслан зогсоох. | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Т.Эрдэнэцэцэг, Б.Батбаяр |
| | **ДҮН** | **61,291.8** | | | |
| **Иргэдийн төлөөлөгчдийн хурал** | | | | | |
| 1 | Үндсэн хөрөнгөд гэр интернет, аяга зараг үндсэн хөрөнгийн шинж | 340.0 | Сангийн сайдын 2006 оны 388 дугаар | Дарга, нягтлан бодогч | М.Ган-Эрдэнэ, Б.Батбар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | чанаргүй хөрөнгийг үндсэн хөрөнгөд орлого авч, элэгдэл тооцсон байна. | | тушаалаар баталсан журамд заасны дагуу үндсэн хөрөнгийг бүртгэх зөвлөмж өгсөн. | | |
| | **ДҮН** | **340.0** | | | |
| **Эрүүл мэндийн төв** | | | | | |
| 1 | Шилэн дансны цахим системд нийт 17 төрлийн 119 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс 29,226.1 мянган төгрөгийн 19 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 29,226.1 | Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлж цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Ц.Цэрэнхүү, Ц.Төмөрбат |
| | **ДҮН** | **29,226.1** | | | |
| **Цэцэрлэг** | | | | | |
| 1 | Шилэн дансны цахим системд нийт 213,795.00 мянган төгрөгийн 119 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс 43,271.5 мянган төгрөгийн 49 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. | 43,271.5 | Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлж цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх гэсэн албан шаардлага өгсөн. | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч,, нягтлан бодогч | Б.Өлзийдүүрэн Б.Чулуундорж |
| 2 | Тайлант онд хүүхдийн хоолны зардлын төсвийн хэмнэлтээр худалдан авалт хийж тайлант хугацааны эцэст 2,748.1 төгрөгийн үлдэгдэлтэй гарч 2,000.0 төгрөгийн хүнсний материалыг илүү нөөцөлж үлдэгдлээр тайлагнасан байна. | 2,000.0 | Худалдан авч нөөцөлсөн хүнсний материалын үлдэгдэл 2,000.0 мянган төгрөгийг суутган тооцож төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон. | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч,, нягтлан бодогч | В.Сангисүрэн, Б.Чулуундорж |
| 3 | Нийт тогтмол зардлаас 3,945.7 мянган төгрөг хэмнээгүй байгаа нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттай нийцэхгүй байна. | 3,945.7 | Цаашид байгууллагын удирдлага гаргасан тогтоол, журам, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн. | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч,, нягтлан бодогч | В.Сангисүрэн, Б.Чулуундорж |
| | **ДҮН** | **49,217.2** | | | |
| **Жинст сумын Соёлын төв** | | | | | |
| 1 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш 59,694.6 мянган төгрөгийн 6 зарлагын гүйлгээ, 46,111.1 мянган төгрөгийн 3 гүйлгээ, 4 дүгээр улирлаар оруулах төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт мэдээлээгүй орхигдуулсан байна. | 105.805.7 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулах зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Т.Цэнд-Аюуш, Ш.Оюунцэцэг |
| 2 | "Өнөрбаянбогд" ХХК-аас 7,000.0 мянган төгрөгөөр фитнесийн тоног төхөөрөмж худалдан авч, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг зөрчсөн байна. | 7,000.0 | Төсвийг зориулалт бусаар зарцуулсан тул төлбөрийн акт тогтоосон. | Дарга, нягтлан бодогч | Т.Цэнд-Аюуш, Ш.Оюунцэцэг |
| | **ДҮН** | **112,805.7** | | | |
| **Сум хөгжүүлэх сан** | | | | | |
| 1 | Тайлант хугацаанд 123,821.8 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд үүнээс хугацаа хэтэрсэн 21376.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл байна. Хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийн 9119.1 мянган төгрөг нь шийхийн шийдвэр гарсан 12257.3 мянган төгрөг шүүхийн шийдвэр гараагүй байна. | 12,257.3 | Зээлийн гэрээний дагуу төлөөгүй 3 зээлдэгчийн 12257.3 мянган төгрөгийн шүүхийн шийдвэр гараагүй тул төлбөрийн акт тогтоосон. | Сумын Засаг дарга, нягтлан бодогч | Р.Батжаргал, Ш.Оюунцэцэг |
| | **ДҮН** | **12,257.3** | | | |
| **Орон нутгийн хөгжлийн сан** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | "Хонгорын шугуй"ХХК-тай нийтийн био нойл хийх 10000.0 мянган төгрөгийн ажлын гэрээг сумын Засаг дарга Р.Батжаргалтай 2021.11.22-ний өдөр байгуулж, 45 хоногийн дотор гүйцэтгэж, урьдчилгаа 100% олгохоор гэрээ байгуулжээ Аудитаар газар дээр нь ажлыг шалгахад ажил эхлээгүй байна. | 10,000.0 | Ажлыг гүйцэтгүүлэн ажлын хэсгийн комиссоор хүлээн авах зөвлөмж өгсөн | Сумын Засаг дарга, нягтлан бодогч | Р.Батжаргал, Ш.Оюунцэцэг |
| 2 | Сумын ИТХ-ын 2021.11.15-ны өдрийн хуралдаанаас тодотголоор Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө үйл ажиллагаанд 14000.0 мянган төгрөгийн төсөв баталсан боловч зарцуулалтаар энэхүү ажиллагаанд 17300.0 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн нь батлагдсан төсвийг 3300.0 төгрөгөөр хэтрүүлсэн байна. | 3,300.0 | Батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулах зөвлөмж өгсөн | Сумын Засаг дарга, нягтлан бодогч | Р.Батжаргал, Ш.Оюунцэцэг |
| 3 | Шилэн дансны тухай хуулийн 6.4.4 т заасан 36822.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг хоцроосон | 36822 | Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлэх зөвлөмж өгсөн | Сумын Засаг дарга, нягтлан бодогч | Р.Батжаргал, Ш.Оюунцэцэг |
| | **ДҮН** | **50,122.0** | | | |
| **Төсвийн шууд захирагчийн тайлангийн алдааны дүн** | | **636,244.6** | | | |

*Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэл*

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сумын Эрүүл мэндийн төв тайлант хугацаанд ЭМД-аас авах санхүүжилтийн 172,153.0 мянган төгрөгийн авлага үүссэн ба цаашид авлагын тооцоог тухайн онд багтаан шийдвэрлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***1. Тодруулгатай холбоотой асуудал***

*1.1.* *__Илрүүлэлт:__* Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах" заалтыг хэрэгжүүлээгүй, төсөвт байгууллагуудын хүрэх тоо болон чанарын үзүүлэлтийг батлаагүй, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-т заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр гаргаагүй байна.

*1.2.* *__Өгсөн зөвлөмж:__* Төсөв хэлэлцэх батлахдаа Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь заалтын дагуу тухайн жилийн төсвийн хүрэх тоо болон чанарын үзүүлэлтийг баталж, хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-т заасны дагуу үр дүнг тайлагнаж, Төрийн аудитын байгууллагад ирүүлж байх.

***2. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал***

*2.1.* *__Илрүүлэлт:__* Сумын Эрүүл мэндийн төвөөс бусад байгууллага санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг сангийн зардал тус бүрээр оруулаагүй, бөөн дүнгээр тэтгэврийн даатгалын зардалд тайлагнасан байна.

*2.2.* *__Өгсөн зөвлөмж:__* Төсвийн хэлбэлзэл, санхүүгийн тайлангийн дүнгээр цалингийн зардал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг Э-тайланд нэр төрлөөр нь тайлагнаж байх.

***3. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал***

*3.1.* ***Илрүүлэлт:*** Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, шат шатандаа хууль, тогтоомжийг мөрдөөгүйгээс 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 636,244.6 мянган төгрөгийн 29 алдаа, зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь "Төсвийн ерөнхийлөн захирагч .....өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.... талаар .. бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

*3.2.* ***Өгсөн зөвлөмж:*** Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж, сумын Засаг дарга, байгууллагын төсвийн захирагч, санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч нарын ажлын хариуцлагыг сайжруулах санхүүгийн албаны дарга нарын хариуцлагыг сайжруулах.

### *4. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал*

***4.1 Илрүүлэлт:*** Тус сумын төсөвт байгууллагуудад тусгай зориулалтын шилжүүлгээс олгох санхүүжилтийг аймгийн Засаг даргын 2021 оны А/742 дугаар захирамжаар сумын ерөнхий боловсролын сургуулийн төсвийг 50,546.4 мянга, цэцэрлэгийн төсвийг 3,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, цэцэрлэгийн төсвийг 1,650.0 мянган төгрөгөөр бууруулсан байхад сумын ИТХ-ын тогтоолоор нэмж тодотгоогүйгээс төсвийн гүйцэтгэлийн тайлан сумын ИТХ-ын тогтоолоос дээрх дүнгээр зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх "Засаг дарга ...дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон ... тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ" гэсэн заалтын хэрэгжүүлээгүй байна.

***4.2. Өгсөн зөвлөмж:*** Сумын Засаг дарга дээд шатны төсөв захирагчаас төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж сумын ИТХ-д өргөн мэдүүлж төсөвт тодотгол оруулж, Төсвийн тухай хуулийн 34.2.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 01-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Хавсралт 1. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Жинст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2022.03.25 | | | БНА-2022/12/СТА-ТТЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Жинст сумын Засаг дарга | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн утга | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Сумын Эрүүл мэндийн төв Эрүүл мэндийн даатгалын сангаас Ковид цар тахлын өвчлөлийн эмчилгээний төлбөрийн санхүүжилт дутуу ирсний улмаас оны эцэст 172,153.0 мянган төгрөгийн авлагатай гарсныг тодруулга тайланд тус авлагыг 5-аас дээш жилийн насжилтаар бүртгэсэн, төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоог э-тайланд оруулаагүй байна. | 172,153.0 | Сангийн яамны Э-тайлан дахь авлагын тодруулгын насжилтыг залруулсан. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Р.Батжаргал, П.Наранбаатар |
| 2 | Жинст сумын сум хөгжүүлэх сангаас 2021 онд 2 аж ахуйн нэгжид 70,000.0 мянган төгрөгийн зээл олгосон байхад авлагын тодруулга тайланд 5-аас жилээс дээш насжилттайгаар, сумын Соёлын төв 2021 онд үүссэн 463.8 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн акттай байхад тооцоо нийлсэн актгүйгээр тайлагнасан байна. | 70,463.8 | Сангийн яамны Э-тайлан дахь авлагын тодруулгын насжилт, өглөгийн тооцоо нийлсэн маягтын үзүүлэлтийг залруулсан. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Р.Батжаргал, П.Наранбаатар |
| 3 | Төсвийн гүйцэтгэлийн тайланд албан хаагчдын тоог сумын сургууль 1, ИТХ 1, ЭМТ 1, Соёлын төв 1-ээр зөрүүтэй оруулсан байна. | 0 | Сангийн яамны Э-тайлан дахь албан хаагчдын тооны зөрүүг залруулсан. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Р.Батжаргал, П.Наранбаатар |
| 4 | Сумын ерөнхий боловсролын сургууль тайлант онд үнэ төлбөргүй ирсэн 3.350.635.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Э-тайланд үр дүнгийн тайланд оруулахдаа 120018 дансаар тайлагнаагүй 120045 дансаар тайлагнасан байна. | 0 | Сангийн яамны Э-тайлан дахь үр дүнгийн тайланд дансыг залруулсан. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Р.Батжаргал, П.Наранбаатар |
| 5 | Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, шат шатандаа хууль, тогтоомжийг мөрдөөгүйгээс 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 636,244.6 мянган төгрөгийн 29 алдаа, зөрчил илэрсэн байна. | 0 | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж, сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга нарын хариуцлагыг сайжруулах. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Р.Батжаргал, П.Наранбаатар |
| 6 | Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр | 0 | Төсөв хэлэлцэх батлахдаа Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь заалтын дагуу тухайн жилийн төсвийн хүрэх | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Р.Батжаргал, П.Наранбаатар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлээгүй, төсөвт байгууллагуудын хүрэх тоо болон чанарын үзүүлэлтийг батлаагүй, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-т заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр гаргаагүй байна. | | үзүүлэлтийг баталж, хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-т заасны дагуу үр дүнг тайлагнаж, Төрийн аудитын байгууллагад ирүүлж байх зөвлөмж өгсөн. | | |
| 7 | Тус сумын төсөвт байгууллагуудад тусгай зориулалтын шилжүүлгээс олгох санхүүжилтийг аймгийн Засаг даргын 2021 оны А/742 дугаар захирамжаар 51,896.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлснийг сумын ИТХ-ын тогтоолоор нэмж тодотгоогүйгээс төсвийн гүйцэтгэлийн тайлан сумын ИТХ-ын тогтоолоос дээрх дүнгээр зөрүүтэй байна. | 0 | Сумын Засаг дарга дээд шатны төсөв захирагчаас төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж сумын ИТХ-д өргөн мэдүүлж төсөвт тодотгол оруулж, Төсвийн тухай хуулийн 34.2.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Р.Батжаргал, П.Наранбаатар |
| 8 | Сумын Эрүүл мэндийн төвөөс бусад байгууллага санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг сангийн зардал тус бүрээр оруулаагүй, бөөн дүнгээр тэтгэврийн даатгалын зардалд тайлагнасан байна. | 0 | Төсвийн хэлбэлзэл, санхүүгийн тайлангийн дүнгээр цалингийн зардал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг Э-тайланд нэр төрлөөр нь тайлагнаж байх зөвлөмж өгсөн. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Р.Батжаргал, П.Наранбаатар |
| **Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангийн алдааны дүн** | | **242,616.8** | | | |

---oOo---